



**МОНГОЛБАНКНААС МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛЧДИЙН ДУНД  
ЗОХИОН БАЙГУУЛДАГ “ШИЛДЭГ ЭДИЙН ЗАСГИЙН НИЙТЛЭЛ”  
УРАЛДААНЫ УДИРДАМЖ (2017 оны II улирал)**

## **НЭГ. СЭДЭВ: “ҮНИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ”**

Тайлбар:

Эдийн засагт ажилгүйдэл, ядуурал, ДНБ-ийн өсөлт, валютын ханш г.м. олон асуудлууд бий. Харин улс орны төв банкууд үнийн тогтвортой байдлыг онцгойлон анхаардаг бөгөөд, эдийн засаг нь амжилттай яваа орнуудад төв банкууд урт хугацаанд инфляцийг тогтвортой байлгахыг үндсэн зорилтоо болгож ажиллах нь нийтлэг болжээ.

Мөнгөний бодлогоор эдийн засгийн бусад асуудлуудыг шийдэх гэсэн оролдлого нь өөрөө урт хугацаанд амжилттай болоогүйгээс гадна, үнийн тогтвортой байдалд ч сөргөөр нөлөөлсөн түүх олон улсад цөөнгүй. Жишээ нь, мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэх замаар эдийн засгийг түр хугацаанд идэвхжүүлж чадсан ч, энэ нь цаашид үнийн хөөсрөлийг бий болгож улмаар эдийн засгийн уналтыг үүсгэсэн тохиолдлууд бий. Иймд инфляцийг тогтвортой хадгалах нь төв банк эдийн засагтаа оруулж буй хамгийн чухал хувь нэмэр гэж үзэх хандлага эдийн засагчдын дунд нэлээд дэлгэрсэн байдаг.

Тэгвэл “Үнийн тогтвортой байдал” сэдвийн хүрээнд үнийн тогтвортой байдлын ач холбогдол, төв банкууд яагаад үнийн тогтвортой байдлыг хангахыг зорьж ажилладаг, үүнтэй холбоотой олон улсын (Монголыг оруулаад) сайн муу туршлагууд г.м. асуудлуудыг хамруулан дүгнэж нийтлэл бичнэ үү.

## **ХОЁР. ШАЛГАРУУЛАЛТ**

### **✓ Шагнал:**

I байр: 400,000 төгрөг + Өргөмжөл

II байр: 300,000 төгрөг + Өргөмжөл

III байр: 200,000 төгрөг + Өргөмжөл

✓ **Материал хүлээн авах хугацаа:** 2017.06.07 (Лхагва) 18.00 цаг хүртэл [essay@mongolbank.mn](mailto:essay@mongolbank.mn) хаягаар хүлээн авна (Subject мөрөнд Сэтгүүлчийн нэр, Ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллага, ).

✓ **Тэмцээний үр дүнг зарлах хугацаа:** 2017.06.21 (Лхагва)

✓ Шалгарсан бүтээлүүдийг Монголбанкны албан ёсны вебсайт, сошиал сувгуудаар олон нийтэд түгээнэ

## **ГУРАВ. НИЙТЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- ✓ Нийтлэлийг 800-1000 үгэнд багтаан бичих;
- ✓ Судалгаа, тоо баримттай байх;
- ✓ Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
- ✓ Нийтлэл бичих ерөнхий бүтцийг баримталсан байх;
- ✓ Бусдын бүтээлийг хуулбарлаагүй байх;
- ✓ Нийтлэлийн бичгийн стандарт:
  - Үсгийн фонд: Times New Roman;

- Үсгийн хэмжээ: 12;
  - Мөр хоорондын зай: 1,5;
  - Margins: top 2 cm, bottom 2 cm, left 3 cm, right 1.5 cm.
- ✓ Нүүр хуудсанд өөрийн овог нэр, ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагын нэр, холбоо барих 2 утас, и-мэйл хаягыг бичих.

## ДӨРӨВ. НИЙТЛЭЛИЙГ ДҮГНЭХ ШАЛГУУР

- ✓ Нийтлэлийг дараах шалгуураар дүгнэнэ:

	Оноо
<b>Ерөнхий шаардлага</b>	
<i>Цаг бартимтлал /18:00 цагаас хоцорсон бол -10 оноо/</i>	10
<i>Үгийн тоо /800-1000 үг/</i>	5
<i>Бичгийн стандарт /Фонт, үсгийн хэмжээ, маржин.../</i>	5
<b>Асуултад хариулсан байдал</b>	
<i>Өөрийн хийдэг зүйлээ тодорхойлсон байдал</i>	10
<i>Нийгэмд бүтээж буй өөрийн үнэ цэнийг тодорхойлсон байдал</i>	10
<b>Эссений чанар</b>	
<i>Үг үсгийн алдаа</i>	5
<i>Найруулга зүй</i>	5
<i>Логик дэс дараалал</i>	10
<i>Судалгаа/Тоо баримт ашигласан байдал</i>	10
<i>Энгийн ойлгомжтой байдал</i>	10
<i>Уншихад сонирхолтой байдал</i>	10
<i>Оригиналь санаа /давтагдаагүй/</i>	10
<b>Нийт</b>	<b>100</b>

**Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “Б” байр**  
**Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв**  
**МОНГОЛБАНК**

Дэлгэрэнгүй мэдээллийг [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn) веб хуудаснаас  
болон (976) 11-310119 утсаар лавлана уу.